



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар

A/41

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар журам, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар журмуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын сургуулийн хоолны заалны ширээ, сандал /Ховд сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Б.Батнасан - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн ахлах мэргэжилтэн

Гишүүдэд: Б.Нямдорж - Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын мэргэжилтэн

М.Адуучин - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Б.Загджүсүм - Иргэний төлөөлөл

Нарийн бичиг: Х.Дэмид - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Б.Батнасан)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Х.Дэмид)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.ЭНХБОЛД